



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/695

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны Х/74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал” ажлын Багц №6: Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Энхийн жаргал констракшн” ХХК-тай 59,500,000 (тавин есөн сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Гантулга)-т үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Энхийн жаргал констракшн” ХХК-ийн захирал (Э.Ундармаа)-д даалгасугай.

3.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 29-ны/ний өдрийн
А/695 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тавигдах нөхцөл, шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Г.Гантулга
2	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
3	Чанарын баталгаа	Гэрээнд зааснаар	Б.Ариунболд Г.Гантулга